

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: УВА-2022/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батсайхан
Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	10
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Дотоод хяналт	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
4.4 Материаллаг байдал	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

додд. 03.15 № ЧВА-додд/03/НА-СТА-ТӨА
танай -ны № -т

УЛААНГОМЫН ДУЛААНЫ
ХОЁРДУГААР СТАНЦ, ТӨХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Улаангомьн дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

АОУС 706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг гараагүй болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудал

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

0200200604

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,010,001.47	33,147,928.04
1.1.02	Дансны авлага	267,582,249.85	307,317,713.55
1.1.04	Бусад авлага	240,314.86	277,000.00
1.1.06	Бараа материал	104,521,717.05	137,272,938.43
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,989,700.00	3,989,700.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	382,343,983.23	482,005,280.02
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	11,874,726,653.23	11,915,421,510.39
1.2.02	Биет бус хөрөнгө	501,403,636.40	495,880,000.25
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,376,130,289.63	12,411,301,510.64
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,758,474,272.86	12,893,306,790.66
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	917,675,735.13	532,867,610.37
2.1.1.02	Цалингийн өглөг	1,445,528.00	1,791,151.00
2.1.1.03	Татварын өр	64,604,720.71	23,209,600.71
2.1.1.04	НДШ - ийн өглөг	23,726,237.63	6,759,026.04
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	14,138,249.31	14,585,390.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	9,035,107.00	12,527,470.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,030,625,577.78	591,740,248.16
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,030,625,577.78	591,740,248.16
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	12,324,965,430.47	12,324,965,430.47
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	161,243,643.48	161,243,643.48
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	494,486,603.26	1,310,608,117.26
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(1,252,846,982.13)	(1,495,250,648.71)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(168,952,730.31)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(1,252,846,982.13)	(1,326,297,918.40)
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,727,848,695.08	12,301,566,542.50
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,758,474,272.86	12,893,306,790.66

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,642,222,462.63	3,211,446,417.03
2	Борлуулалтын өртөг	2,621,129,892.80	3,055,453,373.79
3	Нийт ашиг(алдагдал)	21,092,569.83	155,993,043.24
5	Хүүний орлого	378,925.03	-
8.1	Орлогын дүн	378,925.03	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	73,019,297.54	74,509,461.28
10	Ерөнхий ба удирдлагын зардал	382,152,497.47	369,576,661.21
12	Бусад зардал	4,113,820.00	3,363,924.04
12.1	Зардлын дүн	459,285,615.01	447,450,046.53
17	Бусад ашиг (алдагдал)	(20,164,473.48)	122,504,272.98
17.1	Олз, гарзын дүн	(20,164,473.48)	122,504,272.98
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(457,978,593.63)	(168,952,730.31)
19	Орлогын татварын зардал	37,892.50	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(458,016,486.13)	(168,952,730.31)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(458,016,486.13)	(168,952,730.31)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	12,324,965,430.47	161,243,643.48	486,380,000.00	(739,072,837.15)	12,233,516,236.80
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(55,757,658.85)	(55,757,658.85)
Залруулсан үлдэгдэл	12,324,965,430.47	161,243,643.48	486,380,000.00	(794,830,496.00)	12,177,758,577.95
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(458,016,486.13)	(458,016,486.13)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	8,106,603.26	-	8,106,603.26
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	12,324,965,430.47	161,243,643.48	494,486,603.26	(1,252,846,982.13)	11,727,848,695.08
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(73,450,936.27)	(73,450,936.27)
Залруулсан үлдэгдэл	12,324,965,430.47	161,243,643.48	494,486,603.26	(1,326,297,918.40)	11,654,397,758.81
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(168,952,730.31)	(168,952,730.31)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	816,121,514.00	-	816,121,514.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	12,324,965,430.47	161,243,643.48	1,310,608,117.26	(1,495,250,648.71)	12,301,566,542.50

2.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант хугацааны дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,559,524,626.35	3,670,642,581.77
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,825,463,769.35	3,490,797,330.77
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	100,000,000.00	100,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	634,060,857.00	79,845,251.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,541,598,428.17	3,598,852,473.38
1.2.1	Ажиллагчдад төлсөн	758,879,276.02	865,986,351.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	281,588,430.57	297,496,504.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	299,267,704.68	634,393,363.18
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	502,981,160.00	567,293,057.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	495,031,585.00	319,042,112.61
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	324,102,809.90	332,223,920.22
1.2.9	Бусад мөнгөн зарлага	879,747,462.00	582,417,164.70
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	17,926,198.18	71,790,108.39
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	378,925.03	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	378,925.03	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,760,512.32	44,652,181.82
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	32,760,512.32	44,652,181.82
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,381,587.29)	(44,652,181.82)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(14,455,389.11)	27,137,926.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,465,390.58	6,010,001.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,010,001.47	33,147,928.04

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэсэн дулаан	мян.Гкал	47.3	46.8	55.6	(8.80)	118.8
2	Шугамын алдагдал /биетээр/	мян.Гкал	2.37	2.34	2.78	(0.44)	118.8
	Шугамын алдагдал /хувиар/	хувь	5.0	5.0	5.0	-	100
3	Борлуулсан дулаан	мян.Гкал	44.9	44.5	52.8	(8.36)	118.8
4	Нийт орлого :	мян.төг	2,781,966.0	3,132,163.7	3,335,450.7	(203,287.00)	106.4
	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	мян.төг	2,642,222.5	3,032,163.7	3,211,446.4	(179,282.70)	105.9
	Үйл ажиллаганаы бус орлого	мян.төг	139,743.5	100,000.0	124,004.3	(24,004.30)	124
5	Нийт зардал	мян.төг	3,239,982.5	3,321,411.1	3,504,403.4	(182,992.30)	105.5
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	47,746.4	71,220.9	53,684.5	17,536.40	75.3
6	Нийт ашиг алдагдал	мян.төг	(458,016.5)	(189,247.4)	(168,952.7)	(20,294.70)	89.2
7	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.23	1.10	1.09	0.00	99.6
8	Нийт авлага :	мян.төг	267,822.5	171,231.1	307,594.7	(136,363.60)	179.6
9	Нийт өглөг :	мян.төг	1,030,625.6	623,101.7	591,740.2	31,361.50	94.9
	Үүнээс: Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-	-	
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	1,030,625.6	623,101.7	591,740.2	31,361.50	94.9
10	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян.төг	25,215.5	155,090.0	142,788.9	12,301.10	92.1
11	Ажиллагсдын тоо	тоо	90.0	93.0	90.0	3.00	96.8
12	Нийт цалингийн сан	мян.төг	851,634.0	981,814.6	967,023.6	14,791.00	98.5

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК нь “Увс аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц дулааны эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, дулаан хангамжаар хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус хэрэгжүүлдэг байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалтай хангах

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дулааны шугам сүлжээний шинэчлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 64/2014 тоот актаар, Станцын барилга байгууламж, зуух, даралтад сав, шугам хоолойг 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 68/2014 тоот актаар тус тус Улсын комиссын хүлээн авсан.

Ашиглалтын өмнөх захиргаа нь 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр 60 хүний бүтэц орон тоотойгоор ажилчдыг авч халаалтын улирлыг эхлүүлэн үйл ажиллагаагаа жигдрүүлж, ажиллах хүч ажлын байрны тодорхойлолт, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, бизнес төлөвлөгөө зэргийг гарган шинэ тутам байгууллагыг байгуулан ажиллаж байгаад 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдөр татан буугдсан.

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/67 тоот тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай байгуулагдан “Дулааны хоёрдугаар станц, Дулааны шугам сүлжээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн оноосон нэр бүхий гэрчилгээ авч 70 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаагаа явуулж ажиллаж байгаад 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр татан буугдсан.

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 202 дугаар тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний яам, Хувьцаа эзэмшигчдийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2021 онд 9 удаа зохион байгуулж 41 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2021 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардалд нийт 68,996.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 68,486.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 59,937.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 8,549.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж,

төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно" гэж заасан байна. Энэ хүрээнд компанийн эзэмшилд байгаа газрыг гэрчилгээтэй болгосон байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж 3 орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан Эрчим хүчний яамнаас тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

"Улаангомын дулааны хоёрдугаар станц" ТӨХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,010.0	33,147.9	27,137.9
Авлага	267,582.2	307,317.7	39,735.5
Бусад авлага	240.3	277.0	36.7
Урьдчилгаа	3,989.7	3,989.7	0
Бараа материал	104,521.7	137,272.9	32,751.2
Үндсэн хөрөнгө	11,874,726.6	11,915,421.5	40,694.9
Биет бус хөрөнгө	501,403.6	495,880.0	-5,523.6
Нийт хөрөнгийн дүн	12,758,474.3	12,893,306.8	134,832.5
Өр төлбөрийн дүн	1,030,625.6	591,740.2	-438,885.4
Эздийн өмчийн дүн	11,727,848.7	12,301,566.5	573,717.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,758,474.3	12,893,306.8	134,832.5

Оны эхнээс мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 27,137.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд харилцах данс 33,080.3 мянга, касс 67.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын данс өмнөх оноос 14.8 хувиар буюу 39,735.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны авлагын дансны өсөлт нь айл өрхийн дулааны төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбоотойгоор Засгийн газраас авах дулааны хөнгөлөлт чөлөөлөлтийн 84,872.3 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын бусад материалын үлдэгдэл 31.3 хувь буюу 32,751.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй ба байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 40,694.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 44,652.2 мянга, үнэ төлбөргүй 816,121.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 5,523.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд биет бус хөрөнгийн хорогдол нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 591,740.2 мянган төгрөг болж өмнөх оны эхний өр төлбөрөөс 438,885.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь хууль шүүхийн байгууллага эцэслэн шийдвэрлэгдсэн зарим өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 12,301,566.5 мянган төгрөг болж 573,717.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт эдийн засгийн ирээдүйн үр ашгийн хэмжигдэх бололцоотой бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт, маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний өртөг 434,323.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт нүүрсний зардал, үйлдвэрийн ажилчдын цалин, урамшуулал, хоолны хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэл, цэвэрлэгээ, сэлбэг, ус, үйлдвэрт ногдох үндсэн хөрөнгийн элэгдэл, цахилгаан, хөдөлмөр хамгаалал, шатахуун, тээврийн хөлс, засвар, түрээс, үл хөдлөх хөрөнгийн татвар, агаарын бохирдлын татвар, үнс асгах, үнс тээврийн зардлуудыг хамруулсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөл, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-өөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,132,200.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 3,231,700.0 мянган төгрөгөөр, 99,500.0 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 157,090.1 мянган төгрөгийг төлөвлөсөн байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 22 дугаар тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг нийт орлогыг 3,132,163.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 3,321,411.1 мянган төгрөгөөр, 189,247.4 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 155,090.0 мянган төгрөг байхаар 89,711.1 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 3,335,450.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,504,403.4 мянган төгрөгийн зардал гарган, 168,952.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 3,335,450.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 203,287.0 мянган төгрөг буюу 106.5 хувиар давсан айл өрхийн дулааны үнэ тариф болон хэрэглэгчид нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,504,403.4 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 182,992.3 мянган төгрөг буюу 105.5 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь түлшний зардал нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 11 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 142,788.9 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 168,952.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 20,294.70 мянган төгрөгөөр бууруулсан байгаа нь орлого нэмэгдсэн нөлөөлж байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Увс аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “үр нөлөөтэй” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Улаангомын дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын орлогын тайлангийн нийт зардлын 3,502,903.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 35,029.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны мэдээллийг хяналаа.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 57,700.0 төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	57,700.0	2	57,700.0			

/мянган төгрөг/

Зөвлөмж	1		1			
Нийт дүн	3	57,700.0	3	57,700.0		

Албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 464 дүгээр тогтоолоор баталсан тарифын дагуу ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон оюутны дотуур байрны дулааны төлбөрийг орон сууцны тарифаар тооцож байгаа эсэхийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

															/мянган төгрөгөөр/														
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс																						
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж														
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн													
Санхүүгийн тайлангийн асуудлаар																													
ДҮН																													
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																													
ДҮН																													
НИЙТ ДҮН																													

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/С.БАТСАЙХАН/

2022 оны 3-р сарын 15-ны өдөр